ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/11/**НА**-**СТА**-**ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2022 он	Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Б.Должинжав Утас: 70432545 цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан 4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан 5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан 5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан 6
3. Аудитын тайлан 9
3.1 Ерөнхий зүйл 9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Материаллаг байдал 10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга 10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв 12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг 14
3.8 Аудитын гол асуудал 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал 15
4. Аудитын илрүүлэлт 15
4.1 Залруулсан алдаа 15
4.2 Төлбөрийн акт 15
4.3 Албан шаардлага .....
4.4 Зөвлөмж 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Ст
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт -1	*Санхүүгийн байдлын тайлан*	9
Хүснэгт -2	*Авлагын үлдэгдэл*	10
Хүснэгт -3	*Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл*	11
Хүснэгт -4	*Татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл*	12
Хүснэгт -5	*Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл*	14
Хүснэгт -6	*Түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл*	17

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД СУМЫН ЗАСАГ ДАРГА
Я. ӨМИРХАН ТАНАА

2022.03.25 № 2/131
танай _____-ны №_____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын батлсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	524,139.1	549,735.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,557.3	149,162.1
33	АВЛАГА	226,575.1	193,190.8
34	УРЬДЧИЛГАА	45,890.0	33,690.0
35	БАРАА МАТЕРИАЛ	163,116.8	173,692.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,736,415.1	7,524,325.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,736,415.1	7,524,325.3
39200	Биет хөрөнгө	5,664,549.3	7,452,885.0
39300	Биет бус хөрөнгө	71,865.8	71,440.3
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	6,260,554.2	8,074,060.8
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	17,205.4	8,162.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,205.4	8,162.2
41300	Өглөг	17,205.4	8,162.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,243,348.8	8,065,898.6
51	Засгийн газрын хувь оролцоо	6,243,348.8	8,065,898.6
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,507,216.0	1,507,216.0
51200	Хуримтлагдсан үр дүн	3,047,012.6	4,869,562.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,689,120.3	1,689,120.3
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	6,260,554.2	8,074,060.8

2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН**	4,492,878.6	4,625,824.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	66,790.7	124,217.7
110	Орлогын албан татвар	61,324.0	51,048.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,324.0	51,048.1
113	Хөрөнгийн албан татвар	66	1,072.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,806.6	72,097.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,258,691.4	2,046,365.2
120	Нийтлэг татварын бус орлого	1,258,691.4	2,046,365.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,167,396.4	2,455,241.2
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	3,375,665.2	2,802,978.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,375,665.2	2,802,978.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,589,319.9	2,689,384.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,689,551.2	1,725,984.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	216,243.7	229,640.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,824.8	120,823.4
2104	Хангамж, бараа материалын зардал	127,932.0	113,913.6
2105	Норматив зардал	95,611.4	168,391.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,378.9	11,162.2
2107	Томилолт, зочны зардал	3,308.0	6,300.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	73,392.9	20,147.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,077.0	293,020.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	786,345.3	113,594.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	1,117,213.4	1,822,846.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	296.2

VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН**	1,117,213.4	1,822,549.8

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,126,669.1	5,126,669.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-533.7	-533.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,126,135.4	5,126,135.4
9	Тайлант үеийн үр дүн	1,117,213.4	1,117,213.4
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,243,348.8	6,243,348.8
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,243,348.8	6,243,348.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,243,348.8	6,243,348.8
19	Тайлант үеийн үр дүн	1,822,549.8	1,822,549.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,065,898.6	8,065,898.6

2.4 **Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	**Тайлангийн үзүүлэлт**	**Өмнөх он**	**Тайлант он**
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,276,586.3	2,641,876.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	66,790.7	124,217.7
110	Орлогын албан татвар	61,324.0	51,048.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	61,324.0	51,048.1
113	Хөрөнгийн албан татвар	66	1,072.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,806.6	72,097.6
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,315.6	2,766.1
1181	Газрын төлбөр	164.4	402.
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	326.7	68,928.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,690.1	90,481.2
120	Нийтлэг татварын бус орлого	25,690.1	90,481.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,184,105.5	2,427,177.7
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,085,834.8	2,515,133.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,085,834.8	2,515,133.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,280,277.4	2,403,010.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,665,787.2	1,728,549.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	218,717.9	232,776.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,531.9	103,515.6
2104	Хангамж, бараа материалын зардал	50,997.0	45,741.6
2105	Норматив зардал	111,573.9	163,337.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,774.5	26,536.5
2107	Томилолт, зочны зардал	3,308.0	5,580.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,604.0	32,846.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,983.1	64,126.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	805,557.3	112,123.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	190,751.5	126,743.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	184,759.9	66,038.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	184,759.9	66,038.5
2200	Дотоод эх үүсвэрээр	184,759.9	66,038.5
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-184,759.9	-66,038.5
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-100

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0	100
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	5,991.6	60,604.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	82,565.7	88,557.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	88,557.3	149,162.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	2,509,501,800.00	2,362,080,054.27	-147,421,745.73
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	2,349,280,200.00	2,295,941,574.27	-53,338,625.73
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	2,322,587,300.00	2,273,606,874.27	-48,980,425.73
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	1,706,929,900.00	1,687,836,626.77	-19,093,273.23
210101	Үндсэн цалин	1,138,623,400.00	1,128,264,238.95	-10,359,161.05
210102	Нэмэгдэл	418,064,100.00	409,329,987.82	-8,734,112.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	6,048,000.00	0.00
210104	Урамшуулал	98,064,300.00	98,064,300.00	0.00
210105	Гэрээт ажлын хөлс	46,130,100.00	46,130,100.00	0.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	230,436,200.00	230,435,600.00	-600.00
210201	Тэтгэврийн даатгал	162,158,600.00	162,158,700.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	17,069,100.00	17,069,000.00	-100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,655,500.00	13,655,300.00	-200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,414,300.00	3,414,100.00	-200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	34,138,700.00	34,138,500.00	-200.00
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	103,572,100.00	103,515,617.50	-56,482.50
210301	Гэрэл, цахилгаан	19,368,100.00	19,368,099.50	-0.50
210302	Түлш, халаалт	82,874,000.00	82,817,518.00	-56,482.00
210303	Цэвэр, бохир ус	1,330,000.00	1,330,000.00	0.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	39,886,000.00	39,861,900.00	-24,100.00
210401	Бичиг хэрэг	5,095,700.00	5,095,700.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	23,830,300.00	23,830,300.00	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,026,100.00	6,026,100.00	0.00
210404	Ном, хэвлэл	345,700.00	345,700.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,681,800.00	2,657,700.00	-24,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,906,400.00	1,906,400.00	0.00
2105	**Норматив зардал**	149,843,300.00	120,289,987.00	-29,553,313.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,866,900.00	23,866,900.00	0.00
210502	Хоол, хүнс	120,513,600.00	90,960,287.00	-29,553,313.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,462,800.00	5,462,800.00	0.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	7,053,500.00	7,053,500.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,000,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгаллын хэрэглэл	267,000.00	267,000.00	0.00
210604	Урсгал засвар	5,786,500.00	5,786,500.00	0.00
2107	**Томилолт, зочны зардал**	5,562,200.00	5,468,000.00	-94,200.00

210702	Дотоод албан томилолт	5,562,200.00	5,468,000.00	-94,200.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	17,659,800.00	17,659,800.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,155,800.00	14,155,800.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,721,000.00	1,721,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	445,000.00	445,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	210,000.00	210,000.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	55,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	0.00
210807	Газрын төлбөр	123,000.00	123,000.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00	0.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	61,644,300.00	61,485,843.00	-158,457.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,458,200.00	51,299,743.00	-158,457.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,186,100.00	10,186,100.00	0.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	26,692,900.00	22,334,700.00	-4,358,200.00
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	26,692,900.00	22,334,700.00	-4,358,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	25,845,900.00	21,487,700.00	-4,358,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	847,000.00	847,000.00	0.00
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	109,221,600.00	66,038,480.00	-43,183,120.00
220001	Барилга байгууламж	37,500,000.00	0	-37,500,000.00
221001	Их засвар	23,755,000.00	18,071,880.00	-5,683,120.00
222001	Тоног төхөөрөмж	10,040,000.00	10,040,000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	37,926,600.00	37,926,600.00	0.00
23	**ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ**	51,000,000.00	100,000.00	-50,900,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	51,000,000.00	100,000.00	-50,900,000.00
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	2,509,501,800.00	2,486,118,858.43	-23,382,941.57
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	1,726,408,200.00	1,683,762,945.43	-42,645,254.57
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,726,408,200.00	1,683,762,945.43	-42,645,254.57
32	**ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	688,538,300.00	689,378,321.00	840,021.00
320001	Орон нутгийн төсвөөс	606,855,200.00	607,695,200.00	840,000.00
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	81,683,100.00	81,683,121.00	21.00
33	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	37,810,300.00	30,081,340.00	-7,728,960.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,810,300.00	30,081,340.00	-7,728,960.00
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	56,745,000.00	82,896,252.00	26,151,252.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000.00	528,000.00	-77,000.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,500,000.00	82,368,252.00	30,868,252.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,640,000.00	0	-4,640,000.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	15,371,443.00	15,371,443.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	139,410,247.16	139,410,247.16
6	**ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ**	904	5,695.00	4,791.00
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	15	15	0.00
610001	Төсвийн байгууллага	15	15	0.00
62	**АЖИЛЛАГСАДЫН ТОО**	156	156	0.00
620001	Удирдах ажилтан	13	13	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	78	78	0.00
620003	Үйлчлэх ажилтан	40	40	0.00
620004	Гэрээт ажилтан	25	25	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	159,963,459.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	159,963,459.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	129,403,459.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,712,476.00
210102	Нэмэгдэл	40,212,476.00
210104	Урамшуулал	500,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,341,038.00
210201	Тэтгэврийн даатгал	2,341,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,879,682.00
210401	Бичиг хэрэг	1,165,247.00
210402	Тээвэр, шатахуун	3,397,805.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,316,630.00
2105	Норматив зардал	43,047,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	43,047,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,483,020.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,400,000.00
210602	Тавилга	9,997,500.00
210604	Урсгал засвар	7,085,520.00
2107	Томилолт, зочны зардал	112,000.00
210702	Дотоод албан томилолт	112,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,186,593.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,186,593.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,641,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,077,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	564,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,560,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,200,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	360,000.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	360,000.00
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	159,963,459.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	159,963,459.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,040,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	48,108,419.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,769,040.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	87,046,000.00

3. **Аудитын тайлан**

3.1 **Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь авлага, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, татварын орлогын төлөвлөлт, түүнчлэн аудитаар түүвэрт хамрагдсан ЗДТГ, ИТХ, Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд илэрсэн зөрчлүүдэд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 3 дугаар сарын 17-ноос 2022 оны 03 дугаар сарын 25–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Ховд сумын Засаг дарга 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 07-ны өдөр 1/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, **түүний орчин ба дотоод хяналт**

Ховд сумын засаг дарга нь Төр засгийн болон аймаг, сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг захиргааны байгууллагыг төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөг үйл ажиллагааны стратегийн зорилтын "Алсын хараа-2050" Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр нийт 6 зорилт 167 арга хэмжээг төлөвлөж 82 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна.

Тайлант хугацаанд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар “Төсвийн зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”*
- *Малын тоо толгойн албан татварын тухай хууль*
- *Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль*
- *Коронавируст халдвар /ковид*-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай*

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"*

Удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзлээ.

Сумын хэмжээнд тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журмын дагуу "цахим Э-тайлан" программ хангамж ашиглан санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Тухайн тайлант оны 2 дугаар улиралд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ажлын хэсэг байгуулан төсөвт байгууллагуудын хөрөнгийн ашиглалт хамгаалалтын байдалд, мөн сумын санхүү албанаас эрүүл мэндийн төв, соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөмж чиглэл өгч ажилласан байна.

3.3 **Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд түүвэрт хамруулан гүйцэтгэж буй байгууллага, тусгай сангийн ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай гэж үнэлсэн.

3.4 **Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 2509.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 50.2 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 40.2 сая төгрөгөөр тогтоов.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 **Санхүүгийн тайлангийн тодруулга**

Ховд сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1813.5 сая төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

Хүснэгт-1 Санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
МӨНГӨН ХӨРӨНГӨ	88,557.3	149,162.1	60,604.8	168%
АВЛАГА	226,575.1	193,190.8	-33,384.3	85%
УРЬДЧИЛГАА	45,890.0	33,690.0	-12,200.0	73%
БАРАА МАТЕРИАЛ	163,116.8	173,692.6	10,575.8	106%
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,736,415.1	7,524,325.3	1,787,910.2	131%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,260,554.2	8,074,060.8	1,813,506.6	129%
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,205.4	8,162.2	-9,043.2	47%
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,243,348.8	8,065,898.6	1,822,549.8	129%

ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,260,554.2	8,074,060.8	1,813,506.6	129%

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 88.6 сая төгрөг байсан бол оны эцэст 149.2 сая төгрөг болж 60.6 сая төгрөгөөр буюу 68 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 149.2 сая төгрөгийн 7.9 сая төгрөг нь орон нутгийн ерөнхий орлогын төрийн сан дахь харилцах дансанд, 57.0 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн сангийн дансанд, 80.0 сая төгрөг нь сум хөгжүүлэх сангийн дансанд, 2.4 сая төгрөг нь эрүүл мэндийн төвийн төрийн сангийн харилцах дансанд тус тус үлдсэн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 226.6 сая төгрөг байсан бол оны эцэст 193.2 сая төгрөг болж 33.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт-2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

33	**АВЛАГА**	226,575.1	193,190.8
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	834.3	3,821.2
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	0.0	28,063.5
33300	Татаас, санхүүжилтийн авлага	16,709.0	0.0
33510	Байгууллагаас авах авлага	298.3	16,039.7
33600	Зээлийн авлага	208,733.4	145,266.3
34	**УРЬДЧИЛГАА**	45,890.0	33,690.0
34300	Тусгай зориулалтын сан	40,000.0	32,000.0
34600	Урьдчилж гарсан зардал	4,200.0	0.0
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,690.0	1,690.0

Авлага дансны үлдэгдэл 226.9 сая төгрөг байгаагаас 69.5 сая төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй авлага ба үүнээс 0.3 сая төгрөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна. Мөн төсвийн 5 байгууллага нийт 6.2 сая төгрөгийн цалингийн сангийн хэмнэлтийг НДШ, ХХОАТ-т шилжүүлж авлага үүсгэсэн зэрэг зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Он дамжсан, насжилт өндөртэй авлагад СХС-аас 2010-2016 оны хооронд олгосон 5 иргэнтэй холбоотой 41.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл, ОНХС-аас малжуулах төслөөр 2014-2018 оны хооронд олгосон 15 иргэнтэй холбоотой 26.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад зохих шийдэл гаргаагүй, хугацаа хэтэрсэн хоногт ногдох алданги тооцож нэхэмжлээгүй зэргээс төрд ихээхэн хохирол учруулах эрсдэл бий болгож байна.

3.5.3 Бараа материал

Бараа материал дансны оны эхний үлдэгдэл 163.1 сая төгрөг байсан бол оны эцэст 173.7 сая төгрөг болж 10.6 сая төгрөгөөр өссөний материаллаг нөлөө нь тусгай зориулалтын материал, аж ахуйн материал материал, мал амьтдын данстай холбоотой байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 338.9 сая төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр 17.2 сая төгрөгийн бараа материал хүлээн авч, 345.6 сая төгрөгийн бараа материал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 7049.7 сая төгрөг байсан бол оны эцэст 9005.9 сая төгрөг болж 1956.2 сая төгрөгөөр өсжээ. Үүнд 21.5 сая төгрөгийн хөрөнгийг үндсэн болон нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээс худалдан авч, 2014.3 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч, 79.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хассан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн оны эхний үлдэгдэл 17.2 сая төгрөг байсан бол оны эцэст 8.2 сая төгрөг болж 9.0 сая төгрөгөөр буурсан байна. Өр төлбөрийн эцсийн үлдэгдэлд эрүүл мэндийн төвийн 5.5 сая, ЕБС-ийн 1.9 сая нийт 7.4 сая төгрөгийн өр төлбөр материаллаг нөлөө үзүүлж байгаа ба нийт өр төлбөрийн 90.2 хувийг эзэлж байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 6243.3 сая төгрөг байсан бол оны эцэст 8065.9 сая төгрөг болж 1822.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 **Төсвийн төлөвлөлт**, **гүйцэтгэл**, **нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 **Төсвийн төлөвлөлт**

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2252.2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 2252.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн нийт зарлагыг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03 өдрийн 3/03 тоот тогтоолоор 2324.4 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсантай холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн аймгийн ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 05-ны 4/03 тоот тогтоолоор нийт 2509.5 сая төгрөгөөр баталсан байна.

3.6.2 **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 2509.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,726.4 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 606.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 81.7 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 37.8 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 51.0 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 1.1 сая төгрөгийн төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоос 4.6 сая төгрөгийг ОНХС, ИТХ-ын урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл Хүснэгт-3 /сая төгрөг/

Ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,509,501.8	2,486,118.9	(23,382.9)
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,726,408.2	1,683,762.9	(42,645.3)
Орон нутгийн төсвөөс	606,855.2	607,695.2	840.0
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	81,683.1	81,683.1	0.0
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,810.3	30,081.3	(7,729.0)
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605.0	528.0	(77.0)
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,500.0	82,368.3	30,868.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	4,640.0	-	(4,640.0)

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,726.4 сая, орон нутгийн төсвөөс 607.7 сая, орон нутгийн хөгжлийн сангаас 81.7 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 30.1

сая, сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 70.2 сая, ОНХС-д 12.2, төсөвт байгууллагын өөрийн орлого 0.5 сая нийт 2528.8 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлж, ТЗШ-ийн санхүүжилтээс 42.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2362.1 сая төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 19.1 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.1 сая, норматив зардлыг 29.5 сая, томилолт, зочны зардлыг 0.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 сая, урсгал шилжүүлгийг 4.3 сая, хөрөнгийн зардлыг 43.2 сая, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардлыг 50.9 сая төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж, хуваарилах Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хянахад анхны батлагдсан төсвөөс 232.4 сая төгрөг хэмнэж төлөвлөх байтал тодотголоор 185.1 сая төгрөг нэмж төлөвлөсөн, харин нийт зардлаас 147.4 сая төгрөгийн хэмнэлт гарган ажилласнаас дүгнэхэд ЗГ-ын 43 дугаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.

Суурь орлогыг 7.8 хувиар буюу 9.5 сая төгрөгөөр давуулж, үүнээс татварын орлогыг 5.9 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр давуулж, татварын бус орлогыг 51.7 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлжээ.

Хүснэгт 4. Сумын суурь орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл */сая.төгрөг/*

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	**СУУРЬ ОРЛОГО**	122,291.3	131,802.7	9,511.4	107.8
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	117,291.3	124,217.7	6,926.4	105.9
110002	Үйл ажиллагааны орлого	2,000.0	15,472.1	13,472.1	773.6
110003	Хөрөнгийн орлого	22,000.0	30,173.4	8,173.4	137.2
110008	Шууд бус орлого	13,650.0	5,402.6	-8,247.4	39.6
113002	Бууны албан татвар	2,244.0	1,072.0	-1,172.0	47.8
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2,842.0	2,033.1	-808.9	71.5
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,300.0	504.0	-1,796.0	21.9
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	800.0	229.0	-571.0	28.6
118101	Газрын төлбөр	555.3	402.5	-152.8	72.5
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	68,400.0	68,411.5	11.5	100.0
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,000.0	200.0	-800.0	20.0
118204	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	1,500.0	317.4	-1,182.6	21.2
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	5,000.0	7,585.0	2,585.0	151.7
120	Нийтлэг татварын бус орлого	5,000.0	7,585.0	2,585.0	151.7
120003	Торгуулийн орлого	5,000.0	7,585.0	2,585.0	151.7

Эх сурвалж: Ховд сумын ТТЗ-ын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Орлого давж биелэхэд материаллаг нөлөө үзүүлсэн нь үйл ажиллагааны орлого 13.5 сая, хөрөнгийн орлого 8.2 сая төгрөгөөр тус тус давж биелснээс шалтгаалжээ.

Дээрх орлого материаллаг хэмжээгээр давж биелсэн шалтгаан нь орлогын төлөвлөлтийг өмнөх оны суурь үзүүлэлтэд үндэслэн бодитой төлөвлөөгүй зөрчил байна. Тухайлбал: Үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 2018 онд 1.2 сая, 2019 онд 3.7 сая, 2020 онд 8.6 сая төгрөг болж өссөн үзүүлэлттэй байхад 2021 онд 2.0 сая төгрөгөөр төлөвлөсөн, хөрөнгийн орлого 2018 онд 20.7 сая, 2019 онд 24.6 сая, 2020 онд 24.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2021 онд 22.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 160.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлснээс 5.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 48.1 сая төгрөгийг дээд шатны байгууллагаас, 19.8 сая төгрөгийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого, 87.0 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас тус тус хууль, журамд нийцүүлэн орлогын эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг байгууллагаар задалбал ИТХ 0.3 сая, эрүүл мэндийн төв 122.6 сая, ЕБС 11.5 сая, хүүхдийн цэцэрлэг 0.4 сая, соёлын төв 1.0 сая, ЗДТГ 24.2 сая нийт 160.0 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, 159.6 сая төгрөгийг зориулалтын дагуу холбогдох арга хэмжээнд зарцуулж, 0.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна.Үүнд:

- Сум хөгжүүлэх сангаас 2013-2019 онуудад олгосон 31 зээлдэгчийн 145.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэйгээс 7 зээлдэгчийн 47.6 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээл байна. Хугацаа хэтэрсэн зээлээс 2022 оны 1 дүгээр улиралд 2 иргэн нийт 6.1 сая зээлийг бүрэн барагдуулж, 5 иргэнтэй холбоотой 41.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй ба тухайн зээлийг барагдуулахад зохих арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх тэмцэхтэй холбоотой хувь иргэн, ААН, байгууллагуудаас 4.7 сая төгрөгийн бараа материал, хандив цугларч, 4.7 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулжээ.
- Тайланд хугацаанд 410 хүн ковид 19 цар тахлаар өвчилж 87.1 сая төгрөгийг эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эм тариа, нэг удаагийн эмнэлгийн хэрэгсэл зэрэг үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх дараах асуудал байна. Үүнд:

Ховд сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн данс өмөнх оноос 1956.2 сая төгрөгөөр нэмэгдсэний гол нөлөө нь УТХО-оор 1850.0 сая төгрөгийн өртөг бүхий 240 хүүхдийн хичээлийн байр шинээр баригдсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар Улаан бураа багийн Долоогийн голд 80.0 сая төгрөгийн гүүр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.9 **Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийн иж бүрэн, үнэн зөв байдал хангалтгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн ба 4 албан шаардлагаас 3 албан шаардлагыг хэрэгжүүлж, 1 албан шаардлагын хэрэгжилт дутуу, 4.7 сая төгрөгийн 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулж ажилласан байна.

3.11 **Дараагийн аудитаар анхаарах асуудал**

“Вивазоне”, ХХК-тай байгуулсан халаалт, концессын гэрээний нөхцөлийг дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 6 төсвийн байгууллага, 2 тусгай сан нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 5 тайланг түүвэрт хамруулан хянасан байна.

Аудитад хамрагдсан байгууллагаас Эрүүл мэндийн төв “Хязгаарлалтай”, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг “Зөрчилгүй” дүгнэлттэйгээр санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулсан байна.

Аудитын дүгнэлт гарсан байгууллагуудад нийт 910.8 сая төгрөгийн 20 алдаа зөрчил илэрч, 108.6 сая төгрөгийн 6 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 802.7 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 5.3 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 төлбөрийн акт тогтоон, 2.8 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага, 794.6 сая төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна.

Аудитад хамрагдсан байгууллагын алдаа, зөрчлийн нэгтгэл : Хүснэгт-5 /сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	**Нийт алдаа, зөрчлийн**		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	**Дүн**	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ЕБС	7	188.1	1	0.6	2	2.0	1	1.7	3	183.8
2	СӨБ	3	27.0	1	0.1	1	1.9			1	25
3	ЭМТ	10	695.7	4	107.9	1	1.4	2	1.1	3	585.8
	Дүн	20	910.8	6	108.6	4	5.3	3	2.8	7	794.6

Эх сурвалж: Ховд сумын ТШЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 306.1 сая төгрөгийн 15 алдаа зөрчил илэрснээс, 1 зөрчлийг залруулж, 0.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 71.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага, 234.6 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан түүвэрт хамрагдсан Соёлын төвийн шилэн дансны дутуу мэдээлсэн мэдээллийг аудитын явцад бүрэн оруулж, зөрчлийг залруулаа.

4.2 **Төлбөрийн акт**

4.2.1 *Илрүүлэлт:* ИТХ цалингийн сангийн хэмнэлт 0.2 сая төгрөгийг оны эцэст НДШ илүү шилжүүлж авлага үүсгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ", гэсэн заалттай нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Илрүүлэлт 4.3.1: СХС-аас 2010-2016 оны хооронд олгосон 5 иргэнтэй холбоотой 41.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахад зохих шийдэл гаргаагүй, хугацаа хэтэрсэн хоногт ногдох алданги тооцож нэхэмжлээгүй зэргээс төрд ихээхэн хохирол учруулах эрсдэл байна.

Шийдвэрлэсэн нь : Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д " Бүх шатны төсвийн захирагч нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.7-д "Бүх шатны төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах үүрэгтэй" гэсэн заалт, сум хөгжүүлэх сангийн зорилго, журамд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

Илрүүлэлт 4.3.2 Иргэдийн Төлөөлөгчдийн хурал цалин хөлс тооцож олгохдоо нарийн бичгийн даргын хууль ёсны нэмэгдэл 3.8 сая төгрөгийн цалин хөлс дутуу тооцож олгож, түүнчлэн гэрээт ажилтанд 3.3 сая төгрөгийн цалин хөлс олгосон зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл 57.2.2-д "Төрийн албан хаагчийн цалин хөлс нь захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс" бүрдэнэ, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д "Төсвийн шууд захирагч нь батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох эрхтэй" гэсэн заалттай тус тус нийцээгүй тул зөрчлийг арилгах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

Илрүүлэлт: 4.3.3 Шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлант хугацаанд оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:, Шилэн дансны тухай хуулийн 4, 6 дугаар зүйлд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

Илрүүлэлт: 4.3.4 Шилэн дансны цахим мэдээллийн системд сумын ЗДТГ-ын тайлант хугацаанд оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:, Шилэн дансны тухай хуулийн 4, 6 дугаар зүйлд нийцээгүй тул албан шаардлага өгөв.

Илрүүлэлт: 4.3.5 ОНХС-аас малжуулах төслөөр 2014-2018 оны хооронд олгосон 15 иргэнтэй холбоотой 26.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад зохих шийдэл гаргаагүй, хугацаа хэтэрсэн хоногт ногдох алданги тооцож нэхэмжлээгүй зэргээс төрд ихээхэн хохирол учруулах эрсдэл бий болгож байна.

Шийдвэрлэсэн нь : Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д " Бүх шатны төсвийн захирагч нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.7-д "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэсэн заалттай тус тус нийцээгүй тул албан шаардлага өгөв.

4.4. **Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Авлага дансны үлдэгдэл 226.9 сая төгрөг байгаагаас 69.5 сая төгрөгийн авлага нь он дамжсан, насжилт өндөртэй авлага ба үүнээс 0.3 сая төгрөг нь эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Өгсөн зөвлөмж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд сумын нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь төсөвт байгууллага, төсөл сангийн он дамжсан, насжилт өндөртэй эзэн холбогдогч тодорхойгүй авлагын хариуцагчийг тодорхойлж барагдуулахад чиглүүлэн удирдлага арга зүйгээр хангаж, үе шаттай арга хэмжээ хэрэгжүүлж ажиллах.

4.4.2 ***Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Харьяа төсвийн байгууллагууд нь цалингийн зардлыг бодитой төлөвлөөгүй, түүнчлэн бүртгэл тооцооны хяналт суларснаас шалтгаалж цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг бүлэг дотроо ангилал хооронд, мөн цалингийн зардлыг нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай гүйлгэн зарцуулдаг зөрчил түгээмэл байна. Үүнээс шалтгаалж мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайлан дахь зардлын ангилал үнэн зөв тайлагнагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: *Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавын дагуу зардлыг санхүүжүүлэх, бүртгэж тайлагнах*, *түүнчлэн төсвийг бодитой төлөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийн тухай хууль, журмын дагуу төсөвт зохицуулалт хийх зэрэг шийдлүүдэд нягтлан бодогчдыг чиглүүлж, арга зүйгээр хангаж ажиллах.*

4.4.3 ***Татварын орлогын төлөвлөлттэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Татварын орлогын төлөвлөлтийг өмнөх оны суурь үзүүлэлтэд үндэслэн бодитой төлөвлөөгүй зөрчил байна. Тухайлбал: Үйл ажиллагааны орлогын гүйцэтгэл 2018 онд 1.2 сая, 2019 онд 3.7 сая, 2020 онд 8.6 сая төгрөг болж өссөн үзүүлэлттэй байхад 2021 онд 2.0 сая төгрөгөөр төлөвлөсөн, хөрөнгийн орлого 2018 онд 20.7 сая, 2019 онд 24.6 сая, 2020 онд 24.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байхад 2021 онд 22.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлага, удирдамжид нийцүүлэн бодит тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн төлөвлөж болохуйц зарим нэр төрлийн татварын орлогыг зохистой төлөвлөхөд чиглүүлж, хяналт хэрэгжүүлж ажиллах.

4.4.4 ***Төсөвт байгууллагуудын И-баримтын бүрдэлтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Төрийн сан нь төсөвт байгууллагуудын ажил гүйлгээг цахим И-баримтын бүрдэл бүрэн хангаагүй байхад төлбөр гүйцэтгэсэн зөрчил түгээмэл байна.

Зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2015 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7 дугаар зүйлийн 7.13.7-д “Төрийн сан нь энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд гүйлгээ хийхийг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөн ажил төсөвт байгууллагын худалдан авалтын гүйлгээ бүрийг цахим И-баримтын бүрдлийг харгалзан гүйцэтгэх.

4.4.5 ***Төсөв тодотгон батлсан тогтоол шийдвэртэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Ховд сумын 2021 оны төсвийн тодотголыг сумын ИТХ-ын тогтоолоор баталсан боловч нэгтгэн товчоолж орлого, зардлын дүнг батлаагүй, нийт зардлын дүн нь

санхүүжүүлэх эх үүсвэрийн дүнтэй зөрүүтэй, зарим зардлын дүнг тогтоолд тусгаагүй зэрэг зөрчил байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2 дугаар хавсралтаарх сум, дүүргийн төсвийн төслийг батлах маягтын дагуу төсөв батлах.

4.4.6 *ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал*

Илрүүлэлт: ЗДТГ-ын авто машинд олгосон шатахууны тооцоо бодолтод хяналт хэрэгжүүлээгүй, И баримт болон анхан шатны баримт дутуу ажил гүйлгээ данс бүртгэлд тусгасан, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зэрэг 163.9 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

4.4.7 *ИТХ-ын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал*

Илрүүлэлт: Илрүүлэлт: Албаны ажилд зориулж ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгохдоо норм нормативыг баримтлан тооцож олгоогүйгээс батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан 1.2 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.”Бүх шатны төсвийн захирагч нь батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах үүрэг хариуцлага хүлээнэ” 6 дугаар зүйл “төсвийн зарчим” 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцүүллж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

4.4.8 *Соёлын төвийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудал*

Илрүүлэлт: Анхан шатны баримтын бүрдэл дутуу, хангалтгүй байтал данс бүртгэлд тусгасан зөрчил илэрлээ.

Зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн дагуу нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулж дээрх зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дүгээр сарын 3-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. **Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

ТТЗ болон түүвэрт хамрагдсан байгууллагын алдаа зөрчлийн нэгтгэл *Хүснэгт*-6
/сая. төгрөгөөр/

д/д	байгууллагын нэр	**Нийт алдаа, зөрчлийн**		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	**Дүн**	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗахирагч	6	69.5					1	0.0	5	69.5

2	ЗДТГ	2	163.9					1	0.0	1	163.9
3	ИТХ	3	5.2			1	0.2	1	3.8	1	1.2
4	Соёлын төв	2	0.0	1	0.0					1	0.0
5	ОНХС	1	26.0					1	26.0		
6	СХС	1	41.5					1	41.5		
	Дүн	15	306.1	1	0.0	1	0.2	5	71.3	8	234.6

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: Б.ДОЛЖИНЖАВ

Ховд сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	ЗДТГ	**4**	**163.9**					1	0.0	3	163.9
3	ИТХ	**3**	**5.2**			1	0.2	1	3.8	1	1.2
4	Соёлын төв	**2**	**0.0**	1	0.0					1	0.0
5	ОНХС	**1**	**26.0**					1	26.0		
6	СХС	**1**	**41.5**					1	41.5		
	Дүн	**15**	**306.1**	**1**	**0.0**	**1**	**0.2**	**5**	**71.3**	**8**	**234.6**

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: **Х.БОЛДБААТАР**

АУДИТЫН МЕНЕЖЕР: **А.ЦЭЦЭГСҮРЭН**

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: **Б.ДОЛЖИНЖАВ**

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 16 А/2170428 Ховд

ХОА-2022/11/НА/-СТА-ТТЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар цалингийн сангийн хэмнэлт 203360 төгрөгийг оны эцэст НДШ-д илүү шилжүүлж авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв,санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 203360 /Хоёр зуун гурван мянга гурван зуун жаран төгрөг /-ийг төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2022 оны 05 дугаар сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ховд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Х.Тилеухан, нягтлан бодогч Т.Ернур нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *А.ЦЭЦЭГСҮРЭН*

АУДИТОР *Б.ДОЛЖИНЖАВ*

1

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

001050142

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 66 А/217-0428 Ховд

ХОА-2022/11/НА/-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар сумын орон нутгийн хөгжлийн санг түүвэрт хамруулан хянахад орон нутгийн хөгжлийн сангаас малжуулах төслөөр 2014-2018 онд олгосон 15 иргэнтэй холбоотой 26.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад зохих шийдэл гаргаагүй, малжуулах төслийн эргэц удааширч буй зөрчил илэрлээ.

Энэ нь орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам, малжуулах төслийн зээлийн гэрээний үүргийн холбогдох заалт, эргэн төлөлтийн хуваарь, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7-д "Бүх шатны төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах үүрэгтэй", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Малжуулах сангийн 26.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулж, сангийн эргэцийг сайжруулахад зохих шийдлийг гарган биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, санхүү албаны дарга Д.Жолды, ОНХС хариуцсан нягтлан бодогч К.Жанбота нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *А.ЦЭЦЭГСҮРЭН*

АУДИТОР *Б.ДОЛЖИНЖАВ*

2

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 67 А/217 0428 Ховд

ХОА-2022/11/НА/-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангийн тайланг түүвэрт хамруулан хянахад 2010-2016 оны хооронд олгосон 5 иргэнтэй холбоотой 41.5 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахад зохих шийдэл гаргаагүй, хугацаа хэтэрсэн хоногт ногдох алданги тооцож нэхэмжлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны журам, зээлийн гэрээний үүргийн холбогдох заалт, эргэн төлөлтийн хуваарь, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д " Бүх шатны төсвийн захирагч нь хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", 41.2.7-д "Бүх шатны төсвийн захирагч нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах үүрэгтэй" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагад алданги тооцож, зээл авсан иргэн, хуулийн этгээдтэй нэг бүрчлэн тооцоо нийлэх, түүнчлэн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж, тайланг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт[2] ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, санхүү албаны дарга Д.Жолды, СХС хариуцсан нягтлан бодогч К.Жанбота нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР Б.ДОЛЖИНЖАВ

3

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 25 өдөр Дугаар 68 А/2170428 Ховд

ХОА-2022/11/НА/-СТА-ТТЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийхэд шилэн дансны цахим мэдээллийн системд төсвийн төвлөрүүлэн захирагчийн оруулбал зохих зарим мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны хуай хуулийн 4, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "*шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт[1] ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ховд сумын Засаг дарга Я.Өмирхан, санхүү албаны дарга Д.Жолды нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР Б.ДОЛЖИНЖАВ

2

[1] Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

021040051